

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Ахлах аудитор: Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-2442	Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ц.Отгонбаяр Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayrts@audit.gov.mn">Otgonbayrts@audit.gov.mn</a> Р.Отгонжаргал Цахим хаяг: <a href="mailto:Otgonjargalr@audit.gov.mn">Otgonjargalr@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2026 он		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМЫН  
БУГАНТ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Л.ОЮУНЖАРГАЛ  
ТАНАА**

2026.02.25 № СА-2026/130/НА-СА-ТЦБ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөө сумын Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөө сумын Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Ерөө сумын Бугант тосгоны Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн болон Боловсролын сайдын А/415, А/151 дүгээр тушаалаар хуваарилсан 3,499.1 мянган төгрөгийн үнэ бүхий зүрхний цахилгаан бичлэгийн аппарат үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэл тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ерөө сумын Бугант тосгоны Эрүүл мэндийн төв нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа бөгөөд уг бодлого нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна

#### **Бусад асуудлын хэсэг**

Ерөө сумын Бугант тосгоны Эрүүл мэндийн төв нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.5 хувиар дүгнэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>200,019,057.88</b>	<b>247,450,877.91</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4</b>	<b>1,088,974.31</b>	<b>81,566,978.99</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		1,088,974.31	81,566,978.99
31210	Төгрөг		1,088,974.31	81,566,978.99
31211	Төрийн сангийн харилцах		1,088,974.31	81,566,978.99
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5</b>	<b>145,809,476.50</b>	<b>129,125,249.20</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		143,338,986.95	122,190,020.40
33300	Татаас, санхүүжилтийн авлага		-	2,209,094.00
33500	Бусад авлага		2,470,489.55	4,726,134.80
33510	Байгууллагаас авах авлага		1,291,909.55	4,726,134.80
33520	Хувь хүмүүсээс авах авлага		1,178,580.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>53,120,607.07</b>	<b>36,758,649.72</b>
35100	Түүхий эд материал		36,929,392.48	23,511,241.98
35130	Эм боох материал		36,929,392.48	23,511,241.98
35400	Хангамжийн материал		16,191,214.59	13,247,407.74
35410	Бичиг хэргийн материал		463,775.00	8,400.00
35420	Аж ахуйн материал		144,400.00	280,000.00
35460	Хүнсний материал		314,360.00	641,116.00
35470	Бусад хангамжийн материал		15,268,679.59	12,317,891.74
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>964,424,138.52</b>	<b>967,229,738.22</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>964,424,138.52</b>	<b>967,229,738.22</b>
39200	Биет хөрөнгө		958,389,938.52	960,648,138.22
39201	Барилга, байгууламж, орон сууц		715,170,846.00	715,170,846.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(118,876,060.92)	(124,377,300.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		228,099,366.47	209,599,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл		(51,198,322.77)	(50,688,259.39)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		224,655,440.66	241,602,212.40
39206	Хуримтлагдсан элэгдэл		(89,447,074.42)	(93,059,550.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		69,931,560.69	84,170,765.93
39208	Хуримтлагдсан элэгдэл		(24,483,473.14)	(26,307,598.47)
39209	Зам, гүүрийн байгууламж		4,537,655.95	4,537,655.95
39300	Биет бус хөрөнгө		6,034,200.00	6,581,600.00
39301	Программ хангамж		-	552,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-	(4,600.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		6,034,200.00	6,034,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>1,164,443,196.40</b>	<b>1,214,680,616.13</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>8,014,069.97</b>	<b>58,916.76</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>8,014,069.97</b>	<b>58,916.76</b>
41300	Өглөг	<b>9</b>	8,014,069.97	58,916.76
41360	Бусад өглөг		8,014,069.97	58,916.76
41361	Байгууллагад төлөх өглөг		8,014,069.97	58,916.76
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>1,156,429,126.43</b>	<b>1,214,621,699.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>1,156,429,126.43</b>	<b>1,214,621,699.37</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал		371,836,442.38	371,836,442.38
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		371,836,442.38	371,836,442.38

51200	Хуримтлагдсан үр дүн		343,180,828.33	401,373,401.27
51210	Өмнөх үеийн үр дүн		50,727,060.89	343,180,828.33
51220	Тайлант үеийн үр дүн		292,453,767.44	58,192,572.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		441,411,855.72	441,411,855.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>1,164,443,196.40</b>	<b>1,214,680,616.13</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тод-руулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	1,279,406,066.40	1,179,545,936.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		276,143,220.27	1,179,545,936.13
120	Нийтлэг татварын бус орлого		276,143,220.27	104,964,961.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		33,561,896.00	101,046,790.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		33,561,896.00	101,046,790.08
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		229,603,304.27	3,499,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		12,978,020.00	419,071.25
122	Тусламжийн орлого		-	1,095,729,941.35
1221	Хандив тусламж /дотоод/		-	1,095,729,941.35
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого			76,050,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\			76,050,000.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж		-	998,530,974.80
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\		-	998,530,974.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,003,262,846.13	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		59,701,445.19	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		59,701,445.19	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		943,561,400.94	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		943,561,400.94	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	986,952,298.96	1,121,353,363.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ		986,952,298.96	1,121,353,363.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		986,952,298.96	1,060,345,333.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		583,225,170.40	643,414,239.70
210101	Үндсэн цалин		290,141,206.59	309,246,705.26
210102	Нэмэгдэл		234,684,160.91	255,038,200.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт		13,984,647.96	25,051,789.49
210104	Урамшуулал		44,415,154.94	54,077,544.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		68,173,982.05	84,644,591.28
210201	Тэтгэврийн даатгалын зардал		48,207,929.91	52,755,602.86

210202	Тэтгэмжийн даатгалын зардал		5,908,167.69	6,485,933.02
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		3,141,887.34	3,064,283.04
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		2,183,557.07	2,350,022.36
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		8,732,440.04	19,988,750.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		<b>56,983,445.19</b>	<b>59,590,406.94</b>
210301	Гэрэл, цахилгаан		4,831,437.79	10,500,000.00
210302	Түлш, халаалт		43,171,040.00	40,817,106.94
210303	Цэвэр, бохир ус		8,980,967.40	8,273,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал		<b>51,523,193.00</b>	<b>49,529,793.30</b>
210401	Бичиг хэрэг		8,070,235.00	9,812,331.00
210402	Тээвэр, шатахуун		29,275,478.00	27,197,121.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		4,819,000.00	5,897,377.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		7,343,580.00	6,263,963.63
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,014,900.00	359,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>148,836,057.27</b>	<b>101,899,882.14</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		134,931,192.27	86,981,445.14
210502	Хоол, хүнс		13,904,865.00	13,161,827.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		-	1,756,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		<b>21,896,400.00</b>	<b>57,048,159.47</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		14,242,000.00	1,270,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		-	14,280,859.47
210604	Урсгал засвар		7,654,400.00	41,496,500.00
2107	Томилолт, зочны зардал		3,120,000.00	3,618,000.00
210702	Дотоод албан томилолт		3,120,000.00	3,618,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,571,363.00	5,315,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,267,070.00	4,615,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		7,262.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		120,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		122,031.00	250,020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		50,622,688.05	55,285,220.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,270,990.00	6,587,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		47,351,698.05	48,697,720.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		-	<b>61,008,030.06</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	<b>6,459,593.06</b>
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	<b>6,459,593.06</b>
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	<b>6,459,593.06</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\		-	<b>6,459,593.06</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг		-	54,548,437.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		-	35,976,437.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,488,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,084,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>292,453,767.44</b>	<b>58,192,572.94</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>292,453,767.44</b>	<b>58,192,572.94</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>902,719,257.18</b>	<b>1,196,776,731.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>33,561,896.00</b>	<b>1,196,776,731.43</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>33,561,896.00</b>	<b>177,096,790.08</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>76,050,000.00</b>
1221	Хандив тусламж /дотоод/	-	76,050,000.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	76,050,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	76,050,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,561,896.00	101,046,790.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,561,896.00	101,046,790.08
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>1,019,679,941.35</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	-	<b>1,019,679,941.35</b>
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	1,019,679,941.35
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	1,019,679,941.35
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>869,157,361.18</b>	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,701,445.19	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,701,445.19	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	809,455,915.99	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	809,455,915.99	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>923,708,619.60</b>	<b>1,068,294,506.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>923,708,619.60</b>	<b>1,068,294,506.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>923,708,619.60</b>	<b>1,013,746,069.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>585,280,795.95</b>	<b>641,710,534.76</b>
210101	Үндсэн цалин	290,141,206.59	304,993,338.78
210102	Нэмэгдэл	236,650,638.46	258,112,986.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,984,647.96	24,740,556.94
210104	Урамшуулал	44,504,302.94	53,863,652.12
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>68,173,982.05</b>	<b>73,503,384.52</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	48,207,929.91	51,404,776.55
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,908,167.69	6,485,933.02
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,141,887.34	3,375,515.59
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,183,557.07	2,563,915.05
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	8,732,440.04	9,673,244.31

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,983,445.19</b>	<b>59,590,406.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,831,437.79	10,500,000.00
210302	Түлш, халаалт	43,171,040.00	40,817,106.94
210303	Цэвэр, бохир ус	8,980,967.40	8,273,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,595,030.00</b>	<b>54,935,089.47</b>
210401	Бичиг хэрэг	5,917,000.00	9,416,806.00
210402	Тээвэр, шатахуун	29,186,330.00	32,237,656.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,819,000.00	5,201,877.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,575,000.00	7,609,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,097,700.00	469,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>136,195,063.41</b>	<b>111,721,991.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	118,030,663.41	94,085,181.00
210502	Хоол, хүнс	15,164,400.00	15,776,810.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	1,860,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,707,100.00</b>	<b>50,782,550.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	1,270,800.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,321,650.00
210604	Урсгал засвар	14,707,100.00	45,190,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,120,000.00</b>	<b>3,618,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,120,000.00	3,618,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,250,163.00</b>	<b>5,177,020.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,895,870.00	4,477,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,262.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,031.00	250,020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,403,040.00</b>	<b>6,247,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,403,040.00	6,247,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>61,008,030.06</b>
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	6,459,593.06
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	6,459,593.06
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	6,459,593.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	54,548,437.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,976,437.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,488,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,084,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(20,989,362.42)</b>	<b>128,482,224.68</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,639,600.00</b>	<b>48,004,220.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,639,600.00</b>	<b>48,004,220.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	20,639,600.00	48,004,220.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,639,600.00	48,004,220.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(20,639,600.00)</b>	<b>(48,004,220.00)</b>

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(41,628,962.42)	80,478,004.68
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,717,936.73	1,088,974.31
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,088,974.31	81,566,978.99

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>371,836,442.38</b>	<b>441,411,855.72</b>	<b>50,727,060.89</b>	<b>863,975,358.99</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,836,442.38	441,411,855.72	50,727,060.89	863,975,358.99
9	Тайлант үеийн үр дүн	-	-	292,453,767.44	292,453,767.44
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>371,836,442.38</b>	<b>441,411,855.72</b>	<b>343,180,828.33</b>	<b>1,156,429,126.43</b>
<b>11</b>	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>371,836,442.38</b>	<b>441,411,855.72</b>	<b>343,180,828.33</b>	<b>1,156,429,126.43</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,836,442.38	441,411,855.72	343,180,828.33	1,156,429,126.43
19	Тайлант үеийн үр дүн	-	-	58,192,572.94	58,192,572.94
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>371,836,442.38</b>	<b>441,411,855.72</b>	<b>401,373,401.27</b>	<b>1,214,621,699.37</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,417,692,300.00</b>	<b>1,190,317,138.37</b>	<b>227,375,161.63</b>	<b>84.0</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,417,692,300.00</b>	<b>1,190,317,138.37</b>	<b>227,375,161.63</b>	<b>84.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>112,266,000.00</b>	<b>101,046,790.08</b>	<b>11,219,209.92</b>	<b>90.0</b>
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	112,266,000.00	101,046,790.08	11,219,209.92	90.0
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,305,426,300.00</b>	<b>1,089,270,348.29</b>	<b>216,155,951.71</b>	<b>83.4</b>
122001	Хандив тусламж /дотоод/	1,191,280,300.00	1,019,679,941.35	171,600,358.65	85.6
122005	Төсвөөс санхүүжих	114,146,000.00	69,590,406.94	44,555,593.06	61.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,418,781,200.00</b>	<b>1,109,839,133.69</b>	<b>308,942,066.31</b>	<b>78.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,418,781,200.00</b>	<b>1,109,839,133.69</b>	<b>308,942,066.31</b>	<b>78.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,354,778,100.00</b>	<b>1,055,290,696.69</b>	<b>299,487,403.31</b>	<b>77.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>668,074,600.00</b>	<b>641,710,534.76</b>	<b>26,364,065.24</b>	<b>96.1</b>
210101	Үндсэн цалин	286,947,300.00	304,993,338.78	(18,046,038.78)	106.3
210102	Нэмэгдэл	295,745,700.00	258,112,986.92	37,632,713.08	87.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,600,000.00	24,740,556.94	2,859,443.06	89.6
210104	Урамшуулал	57,781,600.00	53,863,652.12	3,917,947.88	93.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,284,300.00</b>	<b>73,503,384.52</b>	<b>9,780,915.48</b>	<b>88.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	56,057,500.00	51,404,776.55	4,652,723.45	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,806,800.00	6,485,933.02	320,866.98	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,403,300.00	3,375,515.59	27,784.41	99.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,403,300.00	2,563,915.05	839,384.95	75.3
210205	Эрүүл мэндийн даатгал	13,613,400.00	9,673,244.31	3,940,155.69	71.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>104,146,000.00</b>	<b>59,590,406.94</b>	<b>44,555,593.06</b>	<b>57.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,700,000.00	10,500,000.00	1,200,000.00	89.7
210302	Түлш, халаалт	83,400,000.00	40,817,106.94	42,582,893.06	48.9
210303	Цэвэр, бохир ус	9,046,000.00	8,273,300.00	772,700.00	91.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>81,964,100.00</b>	<b>54,935,089.47</b>	<b>27,029,010.53</b>	<b>67.0</b>
210401	Бичиг хэрэг	9,900,000.00	9,416,806.00	483,194.00	95.1
210402	Тээвэр, шатахуун	53,714,200.00	32,237,656.00	21,476,544.00	60.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,149,900.00	5,201,877.47	(51,977.47)	101.0
<b>210405</b>	<b>Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал</b>	<b>11,700,000.00</b>	<b>7,609,750.00</b>	<b>4,090,250.00</b>	<b>65.0</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	469,000.00	1,031,000.00	31.3
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>242,908,300.00</b>	<b>111,721,991.00</b>	<b>131,186,309.00</b>	<b>46.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	201,450,400.00	94,085,181.00	107,365,219.00	46.7
210502	Хоол, хүнс	28,457,900.00	15,776,810.00	12,681,090.00	55.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,000,000.00	1,860,000.00	11,140,000.00	14.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>132,860,100.00</b>	<b>98,234,770.00</b>	<b>34,625,330.00</b>	<b>56.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,923,900.00	33,683,800.00	20,240,100.00	62.5

210602	Тавилга	15,000,000.00	15,039,220.00	(39,220.00)	100.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,936,200.00	4,321,650.00	6,614,550.00	39.5
210604	Урсгал засвар	63,000,000.00	45,190,100.00	17,809,900.00	71.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,500,000.00</b>	<b>3,618,000.00</b>	<b>882,000.00</b>	<b>80.4</b>
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	3,618,000.00	882,000.00	80.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,040,700.00</b>	<b>5,729,020.00</b>	<b>9,311,680.00</b>	<b>38.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,749,900.00	5,029,000.00	6,720,900.00	42.8
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	-	1,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	250,020.00	549,980.00	31.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250,000.00	-	250,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240,800.00	450,000.00	790,800.00	36.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,000,000.00</b>	<b>6,247,500.00</b>	<b>5,752,500.00</b>	<b>52.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	6,247,500.00	5,752,500.00	52.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>64,003,100.00</b>	<b>54,548,437.00</b>	<b>9,454,663.00</b>	<b>85.2</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>64,003,100.00</b>	<b>54,548,437.00</b>	<b>9,454,663.00</b>	<b>85.2</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,515,100.00	35,976,437.00	6,538,663.00	84.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,488,000.00	16,488,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	2,084,000.00	2,916,000.00	41.7
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(1,088,900.00)</b>	<b>80,478,004.68</b>	<b>(81,566,904.68)</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>1,088,974.31</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>81,566,978.99</b>	<b>-</b>	<b>-</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	19.00	1.00	95.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3.00	2.00	1.00	66.7

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт **39,088.2** мянган төгрөгийн зөрчил илэрч, 359.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,006.8 төгрөгийн албан шаардлага, 31,721.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,366.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 9,272.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Эмийн эргэлтийн сангийн эмийн жилийн эцсийн тооллогоор 359.6 мянган төгрөг бараа материал дутагдсан боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.6. дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан бараа материалыг холбогдох этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй дараах нийт **2,658.9** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- *Бичиг хэргийн зардлаас багаж, техник хэрэгсэл худалдан авахад **1,300.0** мянган төгрөг,*
- *Тээвэр шатахууны зардлаас эмийн худалдан авахад **330.4** мянган төгрөг,*
- *Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас тавилга эд хогшил худалдан авахад **410.0** мянган төгрөг,*
- *Хоол, хүнс худалдан авах зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх худалдан авахад **618.3** мянган төгрөг гэх мэт.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Аймгийн ЭМГ-ын хяналт шалгалтаар хоол үйлдвэрлэлийн дотоод хяналтын журамгүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй зөрчил илэрч 3,000.0 мянган төгрөг, ЭЭХХЗГ-аас хийсэн хяналт шалгалтаар дотор эмийн санг мэргэжлийн бус хүнээр хариуцуулсан, өдрийн эмчилгээний эмийг нэр усгүй олгосон, хөргөгчийн чийгийн хэмжээг тэмдэглээгүй гэх үндэслэлээр 5,000.0 мянган төгрөг, нийт 8,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна. Уг торгуулийг зөрчил гаргасан албан тушаалтнаар төлүүлэлгүй мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн зардлын батлагдсан төсвөөс **2,500.0** мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсвөөс **5,500.0** мянган төгрөг төлж, төсвийн хөрөнгийн зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх “*Ажилтны хүлээх үндсэн үүрэг*”, 3.4.7 дахь “*Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ биелүүлэх, Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрлөх үүрэгтэй холбоотой гарсан дүрэм журмыг чанд сахих*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд зарцуулсан **4,347.9** мянган төгрөгийн шатахууны тайланд спидометрийн заалтыг зөрүүтэй тусгасан, жолооч хүлээн авсан шатахууны хэмжээгээр зарцуулалтыг гаргасан, нягтлан бодогч ажил гүйлгээг хянаж баталгаажуулаагүй, хэтрэлт хэмнэлтийг тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо болон ажил гүйлгээг хянаж баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Санхүүжилттэй холбоотой асуудал:**

Илрүүлэлт: ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр 31,721.8 мянган төгрөгөөр хасагдсан байгаа нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын

журам”-ын шалгуур болон “*Нийцсэн бөгөөд зохистой*” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэхэмжлэхийн хяналтаар хасагдсан тусламж, үйлчилгээний санхүүжилтэд сар бүр дүн шинжилгээ хийж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх замаар тусламж, үйлчилгээний орлогын бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эмийн эргэлтийн сангийн эмийн үлдэгдэл нь дутуу буюу бодитоор байхгүй зөрчил илэрлээ.	1	359.6	1	359.6								
Зориулалт бусаар зарцуулсан	1	2,658.9			1	2,658.9						
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-							1	-		
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	4,347.9			1	4,347.9						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>7,366.4</b>	<b>2</b>	<b>359.6</b>	<b>1</b>	<b>7,006.8</b>			<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тусламж үйлчилгээний санхүүжилт хасагдсан	1	31,721.8					1	31,721.8
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>31,721.8</b>					<b>1</b>	<b>31,721.8</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>31,721.8</b>					<b>2</b>	<b>31,721.8</b>